



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/190/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2023 он

Дарга,

тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: 70342580

Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: [enhtsoodolj@audit.gov.mn](mailto:enhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: А.Сувдаа

Утас: 70342495

Цахим хаяг: [suvdaaa@audit.gov.mn](mailto:suvdaaa@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
Асуудлыг онцолсон хэсэг .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	18
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	18
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	18
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	18
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	18
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	19
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	19
Зөрчлийг таслан зогсоор албан шаарлагын биелэлт хангалтгүй, зөрчлийг давтан гаргасан тул холбогдох албан тушаалтанд харицлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх. ....	19
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	19
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	20
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	20
1. Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн балансын урамшууллыг 2 сарын үндсэн цалингаар тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3-р хавсралтын 3.3-ыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. ....	20
2. Үйлчлэгч Г.Баасанжавт үр дүн олгохдоо тушаалын дүнгээс дутуу тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. ....	20
3. Албан хаагчдад албан томилолтын хугацаанд хоолны мөнгө давхардуулж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. ....	20
4. Шатахууны зардлыг нормоос илүү тооцож олгосон нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1-р хавсралтад заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. ....	20
<b>5.2 Албан шаардлага</b> .....	20
Албан томилолтоор ажиллах хугацаанд анхан шатын бүрдэл дутуу байрны зардал олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй. ....	20
<b>5.3 Зөвлөмж</b> .....	20

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... 21**

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 87  
ганай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ДАРГА С.НАРАНТУЯА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн газар 2 хөтөлбөр 3 зориулалт арга хэмжээний хүрээнд 2,261,764.1 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 2,223,944.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд 2,819.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч 154,599.2 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч нийт 157,418.9 мянган төгрөгөөр нэмэгдэн, ЭМЯ болон ХӨСҮТ-ээс 1,665,513.9 мянган төгрөгийн эм боох, 22,670.9 мянган төгрөгийн хангамжийн материал шилжүүлэн авч данс бүртгэлд тусгажээ.

### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

#### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>433,319,318.56</u></b>	<b><u>367,718,443.32</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,000,000.00	170,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,000,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	170,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	170,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	428,319,318.56	367,548,443.32
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	380,195,487.06	314,615,093.37
35110	Тусгай зориулалттай материал	961,500.00	-
35130	Эм боох материал	379,233,987.06	314,615,093.37
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	48,123,831.50	52,933,349.95
35410	Бичиг хэргийн материал	994,500.00	-
35440	Түлш, шатах тослох материал	1,298,520.00	-
35470	Бусад хангамжийн материал	45,830,811.50	52,933,349.95
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>287,841,579.43</u></b>	<b><u>251,014,932.35</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	287,841,579.43	251,014,932.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	271,361,579.43	234,534,932.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	116,057,461.63	116,057,461.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,718,512.96)	(46,129,332.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	191,371,297.00	121,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(95,746,297.02)	(40,991,666.70)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,912,539.92	134,922,138.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,172,207.20)	(59,967,400.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,250,212.00	22,250,212.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,403,446.30)	(17,317,012.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,810,532.36	3,810,532.36
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	16,480,000.00	16,480,000.00
39301	Програм хангамж	935,000.00	935,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(935,000.00)	(935,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,480,000.00	16,480,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>721,160,897.99</u></b>	<b><u>618,733,375.67</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>842,504.98</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	842,504.98	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	842,504.98	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	842,504.98	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>720,318,393.01</u></b>	<b><u>618,733,375.67</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	720,318,393.01	618,733,375.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	241,409,972.17	241,409,972.17
51101	Өмч: - төрийн	241,409,972.17	241,409,972.17
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	388,140,518.83	286,555,501.49
51210	Өмнөх үеийн үр дүн	388,140,518.83	388,140,518.83
51220	Тайлант үеийн үр дүн	-	(101,585,017.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	90,767,902.01	90,767,902.01
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>721,160,897.99</u></b>	<b><u>618,733,375.67</u></b>

/төгрөгөөр/

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>8,184,408,132.32</b>	<b>4,265,841,668.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,093,981,311.31</b>	<b>1,838,628,705.53</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,045,014,115.76	1,728,762,890.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,045,014,115.76	1,728,762,890.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,215,500.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,037,798,615.76	1,728,762,890.06
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	48,967,195.55	109,865,815.47
122001	Хандив тусламж /дотоод/	48,967,195.55	109,865,815.47
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,090,426,821.01</b>	<b>2,427,212,963.02</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,836,559,100.00	2,226,764,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,836,559,100.00	2,226,764,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,253,867,721.01	200,448,863.02
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	170,007,831.01	99,136,535.02
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,285,200.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,015,508,690.00	76,755,828.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,066,000.00	4,556,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,939,252,880.04</b>	<b>4,237,609,604.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,939,252,880.04</b>	<b>4,217,609,604.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5,770,512,200.01	2,609,430,955.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	488,434,764.76	432,163,522.00
210101	Үндсэн цалин	286,300,638.21	306,119,717.00
210102	Нэмэгдэл	139,655,389.94	73,082,865.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,175,000.00	31,054,734.00
210104	Урамшуулал	33,303,736.61	21,906,206.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,942,267.20	54,543,243.32
210201	Тэтгэврийн даатгал	41,863,623.84	38,943,032.28
210202	Тэтгэмжийн даатгал	4,667,982.32	4,157,837.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,687,305.71	3,296,051.32
210204	Ажилгүйдлийн даатгал	883,978.03	740,574.79
210205	Эрүүл мэндийн даатгал	8,839,377.30	7,405,747.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	46,520,452.33	59,056,091.99
210301	Гэрэл, цахилгаан	3,384,228.33	3,022,069.99
210302	Түлш, халаалт	40,326,724.00	53,160,496.00
210303	Цэвэр, бохир ус	2,809,500.00	2,873,526.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	81,150,428.51	80,849,862.00
210401	Бичиг хэрэг	5,576,650.01	6,490,300.00
210402	Тээвэр, шатахуун	50,263,539.40	47,720,408.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,749,833.00	6,553,124.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,042,030.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	252,900.00	18,044,000.00

210408	Бараа материал акталсны зардал	20,307,506.10	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,813,500,515.68	1,730,425,841.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,813,344,115.68	1,730,281,841.48
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	156,400.00	144,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,131,874.00	24,843,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,350,200.00	-
210604	Урсгал засвар	11,781,674.00	24,843,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	53,128,236.00	53,574,200.00
210702	Дотоод албан томилолт	53,128,236.00	53,574,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20,342,015.00	19,458,395.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,664,700.00	16,228,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,990,600.00	1,230,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	991,610.00	704,035.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	94,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,670,385.00	1,176,340.00
210807	Газрын төлбөр	24,720.00	24,720.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	183,361,646.53	154,516,399.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,680,200.00	32,745,645.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	96,505,540.00	57,342,200.02
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,175,906.53	64,428,554.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,168,740,680.03	1,608,178,648.71
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,952,970,765.00	1,533,085,588.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	934,700,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	291,321,065.00	791,486,332.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	702,499,700.00	730,653,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,450,000.00	10,946,156.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	211,974,867.03	70,364,754.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,974,867.03	70,364,754.71
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,795,048.00	4,728,306.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,795,048.00	4,728,306.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>20,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	20,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	20,000,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>245,155,252.28</b>	<b>28,232,064.35</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	6,992,000.00	129,817,081.69
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,992,000.00	129,817,081.69

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>3,097,791,627.01</u></b>	<b><u>2,432,212,963.02</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,364,806.00</b>	<b>5,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,364,806.00	5,000,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	7,364,806.00	5,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,215,500.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	149,306.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	5,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,090,426,821.01</b>	<b>2,427,212,963.02</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,836,559,100.00	2,226,764,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,836,559,100.00	2,226,764,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,253,867,721.01	200,448,863.02
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	170,007,831.01	99,136,535.02
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,285,200.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,015,508,690.00	76,755,828.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,066,000.00	4,556,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>3,080,783,527.01</u></b>	<b><u>2,409,393,163.02</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,080,783,527.01</b>	<b>2,409,393,163.02</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>907,042,846.98</b>	<b>801,214,514.31</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	487,925,334.44	433,176,026.98
210101	Үндсэн цалин	287,964,929.89	307,132,221.98
210102	Нэмэгдэл	137,481,667.94	73,082,865.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,600,000.00	31,054,734.00
210104	Урамшуулал	30,878,736.61	21,906,206.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,115,989.20	54,543,243.32
210201	Тэтгэврийн даатгал	44,037,345.84	38,943,032.28
210202	Тэтгэмжийн даатгал	4,667,982.32	4,157,837.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,687,305.71	3,296,051.32
210204	Ажилгүйдлийн даатгал	883,978.03	740,574.79
210205	Эрүүл мэндийн даатгал	8,839,377.30	7,405,747.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	46,520,452.33	59,056,091.99
210301	Гэрэл, цахилгаан	3,384,228.33	3,022,069.99
210302	Түлш, халаалт	40,326,724.00	53,160,496.00
210303	Цэвэр, бохир ус	2,809,500.00	2,873,526.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	62,413,623.01	64,962,512.00
210401	Бичиг хэрэг	7,138,050.01	8,137,500.00
210402	Тээвэр, шатахуун	49,087,447.00	46,421,888.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,620,226.00	6,553,124.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,906,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,567,900.00	1,943,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	39,968,850.00	2,484,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,115,250.00	2,340,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	853,600.00	144,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,733,900.00	26,593,400.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	902,800.00	-
210604	Урсгал засвар	7,831,100.00	26,593,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	53,128,236.00	53,574,200.00
210702	Дотоод албан томилолт	53,128,236.00	53,574,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20,471,622.00	19,458,395.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,664,700.00	16,228,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,990,600.00	1,230,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	991,610.00	704,035.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	94,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,799,992.00	1,176,340.00
210807	Газрын төлбөр	24,720.00	24,720.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	125,764,840.00	87,366,145.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,106,200.00	20,635,370.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	102,658,640.00	66,730,775.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,173,740,680.03</b>	<b>1,608,178,648.71</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,952,970,765.00	1,533,085,588.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	934,700,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	291,321,065.00	791,486,332.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	702,499,700.00	730,653,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,450,000.00	10,946,156.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	211,974,867.03	70,364,754.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,974,867.03	70,364,754.71
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	8,795,048.00	4,728,306.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,795,048.00	4,728,306.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>17,008,100.00</u></b>	<b><u>22,819,800.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>17,008,100.00</b>	<b>22,819,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17,008,100.00</b>	<b>22,819,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	17,008,100.00	22,819,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,819,800.00
223001	Бусад хөрөнгө	-	20,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,008,100.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(17,008,100.00)</u></b>	<b><u>(22,819,800.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	241,409,972.17	90,767,902.01	151,388,215.05	00.00	483,566,089.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>241,409,972.17</b>	<b>90,767,902.01</b>	<b>151,388,215.05</b>	<b>00.00</b>	483,566,089.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	238,163,252.28	00.00	238,163,252.28
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>241,409,972.17</b>	<b>90,767,902.01</b>	<b>388,140,518.83</b>	<b>00.00</b>	720,318,393.01
D01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>241,409,972.17</b>	<b>90,767,902.01</b>	<b>388,140,518.83</b>	<b>00.00</b>	720,318,393.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>241,409,972.17</b>	<b>90,767,902.01</b>	<b>388,140,518.83</b>	<b>00.00</b>	720,318,393.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-101,585,017.34	00.00	-
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>241,409,972.17</b>	<b>90,767,902.01</b>	<b>286,555,501.49</b>	<b>00.00</b>	618,733,375.67

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,261,764,100.00	2,223,944,300.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,261,764,100.00	2,223,944,300.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	694,821,400.00	625,493,951.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	476,170,600.00	429,328,026.98
210101	Үндсэн цалин	308,741,500.00	307,132,221.98
210102	Нэмэгдэл	100,725,300.00	69,234,865.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,270,000.00	31,054,734.00
210104	Урамшуулал	27,433,800.00	21,906,206.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,473,000.00	54,543,243.32
210201	Тэтгэврийн даатгал	44,666,200.00	38,943,032.28
210202	Тэтгэмжийн даатгал	4,951,700.00	4,157,837.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,961,400.00	3,296,051.32
210204	Ажилгүйдлийн даатгал	990,300.00	740,574.79
210205	Эрүүл мэндийн даатгал	9,903,400.00	7,405,747.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	60,742,400.00	59,056,091.99
210301	Гэрэл, цахилгаан	3,837,000.00	3,022,069.99
210302	Түлш, халаалт	53,476,000.00	53,160,496.00
210303	Цэвэр, бохир ус	3,429,400.00	2,873,526.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,472,800.00	26,882,624.00
210401	Бичиг хэрэг	2,988,000.00	2,988,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,381,500.00	16,381,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,253,300.00	3,663,124.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,906,700.00	1,906,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,943,300.00	1,943,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,136,000.00	2,484,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,340,500.00	2,340,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,795,500.00	144,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,150,700.00	19,708,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,860,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,582,200.00	-
210604	Урсгал засвар	19,708,500.00	19,708,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	10,351,800.00	10,344,200.00
210702	Дотоод албан томилолт	10,351,800.00	10,344,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,426,400.00	5,006,395.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,776,700.00	1,776,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,230,600.00	1,230,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	704,100.00	704,035.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	94,000.00	94,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,496,000.00	1,176,340.00
210807	Газрын төлбөр	25,000.00	24,720.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	-

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,897,700.00	18,140,370.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,912,200.00	16,315,370.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,985,500.00	1,825,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,566,942,700.00	1,528,085,594.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,566,942,700.00	1,528,085,594.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	830,227,200.00	791,486,332.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	730,653,100.00	730,653,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,062,400.00	5,946,162.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>2,819,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	2,819,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,819,800.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	2,226,764,100.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	2,226,764,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	2,226,764,100.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	33.00	33.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	11.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>185,448,863.02</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>185,448,863.02</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	175,720,563.02
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	3,848,000.00
210102	Нэмэгдэл	3,848,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,079,888.00
210401	Бичиг хэрэг	5,149,500.00
210402	Тээвэр, шатахуун	30,040,388.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,890,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,884,900.00
210604	Урсгал засвар	6,884,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	43,230,000.00
210702	Дотоод албан томилолт	43,230,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,452,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,452,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	69225775.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,320,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	64,905,775.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4999994.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,999,994.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,999,994.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,728,306.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	4,728,306.00

<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>20,000,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	20,000,000.00
223001	Бусад хөрөнгө	20,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	200448863.02
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	200,448,863.02
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	99,136,535.02
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,755,828.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,556,500.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Тус байгууллага “Эрүүл мэндийг дэмжих нотолгоонд суурилсан арга хэмжээ, нийгмийн эрүүл мэндийн дэвшилтэт бодлогыг хэрэгжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэх замаар дундаж наслалтыг уртасгана” зорилгын хүрээнд “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах” зорилтыг дэвшүүлсэн ажиллажээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Газрын даргын баталсан 2019 оны А/22 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Мөрдөж буй НБББББ-т журнал бүртгэл хэрхэн хөтлөх талаар тусгаагүй бөгөөд ЭМЯ-аас НБББББ батлах чиглэл ирсэн байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102,427.5 мянган төгрөгөөр буюу 14.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	5,000.00	170.00	(4,830.00)
Бараа материал	428,319.32	367,548.44	(60,770.88)
Үндсэн хөрөнгө	287,841.58	251,014.93	(36,826.65)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>721,160.90</b>	<b>618,733.38</b>	<b>(102,427.52)</b>
Өр төлбөр	842.50	-	(842.50)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	720,318.39	618,733.38	(101,585.02)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>721,160.90</b>	<b>618,733.38</b>	<b>(102,427.52)</b>

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Тус байгууллага тайланд онд хугацаа дууссан эм боох материалыг устгалд оруулсан, тайланд хугацааны элэгдэл бол хуримтлагдсан үр дүн буурснаас нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,237,577.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 107,268.7 мянган төгрөгөөр бууруулж, 2,130,308.9 мянган төгрөгөөр баталсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсөвт ЭМС-ын А/552 дугаар тушаалаар тодотгол хийн 131,455.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,261,764.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,226,764.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,223,944.3 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 37,819.8 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ, зориулалт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ		218,718.6	200,892.3	17,826.2	92%
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	209,398.6	191,572.4	17,826.2	91%
2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	5,000.0	5,000.0	0	100%
3	83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	4,320.0	4,320.0	0	100%
	71603 Эрүүл мэндийн бодлого, удирдлага		2,261,764.1	2,226,764.1	35,000.0	98%
4	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	679,812.8	679,812.8	0	100%
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,566,942.7	1,531,942.7	35,000.0	98%
6	83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	15,008.6	15,008.6	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 71,958.7 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 108,933.6 мянган төгрөгийн санхүүжилт орсноос 200,720.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 2,261,764.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 33,926.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2,370,129.2 мянган төгрөгийн орлого, 1,441,026.8 мянган төгрөгийн зарлага, 63,667.9 мянган төгрөгийн худалдан авалтын мэдээллийг бүрэн мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4,

6.4.5, 6.4.8, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.2.9, 3.2.10-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргасан тул холбогдох ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Албан хэрэгцээнд хувийн авто машин хэрэглэсэн нь Хэмнэлтийн тухай хуулийн 6.3-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

**Шийдвэрлэсэн нь:**

Хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зайлшгүй хувийн автомашин ашиглах тохиолдолд гэрээ байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2. Албан хаагчдад 900.0 мянган төгрөгийн гар утасны зардал олгосон нь Хэмнэлтийн тухай хуулийн 12.1.1-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

**Шийдвэрлэсэн нь:**

Хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг таслан зогсоох, төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр 01/115 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,544.3	2	1,544.3	100
Албан шаардлага	4	10,026.3	4	10,026.3	75
Зөвлөмж	3	845.5	3	845.5	100
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>12,413.2</b>	<b>9</b>	<b>12,413.2</b>	<b>91,7</b>

Зөрчлийг таслан зогсоор албан шаарлагын биелэлт хангалтгүй, зөрчлийг давтан гаргасан тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг нягтлах, биелэлтийг тооцох.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,636.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 25,636.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Өрхийн эрүүл мэндийн төвд автомашин авч өгөхтэй холбоотойгоор Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосныг үндсэн хөрөнгөөр, албан хаагчдад урамшуулал олгохдоо шууд зардлаар бүртгэсэн, албан томилолтоор ажиллах хугацаанд хоолны мөнгө давхардуулж олгосон.

Аудитаар нийт 6,972.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,380.5 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн балансын урамшууллыг 2 сарын үндсэн цалингаар тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3-р хавсралтын 3.3-ыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Үйлчлэгч Г.Баасанжавт үр дүн олгохдоо тушаалын дүнгээс дутуу тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3. Албан хаагчдад албан томилолтын хугацаанд хоолны мөнгө давхардуулж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4. Шатахууны зардлыг нормоос илүү тооцож олгосон нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1-р хавсралтад заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### 5.2 Албан шаардлага

Албан томилолтоор ажиллах хугацаанд анхан шатын бүрдэл дутуу байрны зардал олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Харилцагч байгууллага, иргэнтэй тооцооллыг тухай бүр хийн тайлант хугацаанд өр, авлага үүсгэхгүй байх.

Дээрх зөрчлийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



Шатахууны зардлыг нормоос илүү тооцож олгосон	1	544,8	1	544,8							
Дүн	5	6,972.2	4	2,380.5	1	4,591.7					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, худалдан авалт, тушаал шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүй	1	3,874,824.0			1	3,874,824.0		
Дүн	1	3,874,824.0			1	3,874,824.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Албан хэрэгцээнд хувийн авто машин ашигласан	1	922.8			1	922.8		
Албан хаагчдад 900.0 мянган төгрөгийн гар утасны зардал олгосон	1	900.0	1	900.0				
Дүн	2	1,822.8	1	900.0	1	922.8		
Нийт дүн	3	3,876,646.8	1	900.0	2	3,875,746.8		